



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 08 сарын 12 өдөр

Дугаар A/531

Арвайхээр

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 96 дугаар дүгнэлтийн дагуу Жирэмснээс хамгаалах эм, хэрэгсэл нийлүүлэх тендерийг 66920206 (жаран зургаан сая есөн зуун хорин мянга хоёр зуун зургаа) төгрөгөөр “Эм Эс Ай Си Си” ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Гэрээ байгуулан, бараа нийлүүлэлтийн явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шиваанүрдэв)-т даалгасугай.

3. Шалгарсан гүйцэтгэгч аж ахуйн нэгж санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн өгөхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБОЛД

011100940